

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2024 оны I улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2024 оны 2-р сарын 21-ээс 3-р сарын 4-ний өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны байгууллагуудын нийт 21 судлаачид (цаашид шинжээч)-ын дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

Шинжээчид:

2024 оны I улиралд

- Инфляц бага зэрэг нэмэгдэж 8.5%,
- Эдийн засгийн өсөлт 6.8%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 12.9%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 16.7% байна гэж таамагласан байна.

2024 оны IV улиралд

- Инфляц нэмэгдэж 9.3%,
- Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч 6.4%,
- Бодлогын хүү бага зэрэг буурч 12.2%,
- Зээлийн хүү бага зэрэг буурч 16.5% болно гэж таамагласан байна.

Судалгааны нэгдсэн үр дүн

Огноо	2024 он 1 сар	2024 он I улирал	2024 оны IV улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	8.1%	8.5%	9.3%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	7.0%*	6.8%	6.4%
Төв банкны бодлогын хүү /%/	13.0%	12.9%	12.2%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	17.0%	16.7%	16.5%

* 2023 оны IV улирал

Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2024

I. Инфляц


2023 оны жилийн эцэст Улаанбаатар хотын жилийн инфляц 8.1% болж буурсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 1.7 нэгж хувиар доогуур гарсан байна. Шинжээчид 2024 оны I улиралд инфляц 8.5%, жилийн дараа 9.3% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

Зураг 1. Инфляцын таамаглал




Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны I улиралд инфляц 8.0-8.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 29.4%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны I улиралд инфляц 9.0-9.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 25.7% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2024 оны I улирал/




Энэ удаагийн инфляцын таамаглалын үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурсан хэдий ч цаашид бага зэрэг өсөх хандлагатай байна. Шинжээчид 2024 оны I улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 9.7% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 8.5% гэж таамаглажээ (Зураг 3).

Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт



Инфляцын таамаглалыг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 8.5-8.9% орчимд байна (Зураг 4).


Зураг 4. Ирэх улирлын инфляцын таамаглал /2024 оны I улирал/



II. Эдийн засгийн өсөлт


2023 оны IV улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 7.0% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 0.6 нэгж хувиар өндөр гаржээ. Шинжээчид бодит ДНБ-ий жилийн өсөлт 2024 оны I улиралд 6.8%, 2024 оны эцэст 6.4% гэж таамаглаж байна (Зураг 5).

Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны I улиралд 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 28.8% байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны I улиралд өсөлт 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 20.7% гэж таамаглаж байжээ (Зураг 6).

Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2024 оны I улирал/




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад өсөх хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2024 оны I улирлын бодит ДНБ-ий жилийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 6.0%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 6.8% байна гэж таамаглажээ (Зураг 7).

Зураг 7. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт



Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 6.5-7.0% орчимд байна (Зураг 8).


Зураг 8. Ирэх улирлын бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал /2024 оны I улирал/



Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2024 оны I улиралд дунджаар 12.9%, хамгийн ихдээ 13.0%, хамгийн багадаа 12.0% гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү бага зэрэг буурч 2024 оны IV улиралд 12.2% байна гэж таамаглажээ (Зураг 9).

Зураг 9. Бодлогын хүүний таамаглал



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2024 оны I улиралд бодлогын хүү 13.0% буюу хэвээр хадгалагдана гэсэн таамаглалтай байна (Зураг 10).


Зураг 10. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2024 оны I улирал, хариултын тоогоор/



2022 оны эхэн үеэс үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг аажмаар нэмэгдүүлсээр мөн оны эцэст 13% хүргэснээс хойш өөрчлөөгүй байна. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 4 улирлын судалгаагаар шинжээчдийн таамаглал бага зэрэг буурах хандлага

ажиглагдаж байна. Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны I улирлын бодлогын хүүг 12.7% байна таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.9% байна гэж таамаглажээ (Зураг 11).


Зураг 11. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт



IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2024 оны I улиралд дунджаар 16.7%, хамгийн ихдээ 17.2%, хамгийн багадаа 16.0%-тай байна гэж таамаглажээ. Цаашид зээлийн хүү бага зэрэг буурч 2024 оны IV улиралд 16.5% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

Зураг 12. Зээлийн хүүний таамаглал



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2024 оны I улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 16.6-17.0% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 13).

Зураг 13. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2024 оны I улирал, хариултын тоогоор/



Зээлийн хүүний таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын үр дүнтэй харьцуулан авч үзвэл бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна.

Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны I улиралд зээлийн хүүг 16.8%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 16.7% гарна гэж үзжээ (Зураг 14).

Зураг 14. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт

